

БҮСЧЛЭЛИЙН КОД ОНООХ, ОЛГОХ, МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь бүсчлэлийн кодыг нийтэд хэрэглүүлэхтэй холбогдуулан бүсчлэлийн код оноох, олгох, мэдээллийн санг бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, мэдээллийн санд өөрчлөлт оруулах харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нэр томъёо

- 2.1. “Бүсчлэлийн код (зип код*)”¹ гэж Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн болон хот суурингийн хэсэг (бүс)-ийн байршлын тухай мэдээллийг агуулж, тэдгээрийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулалт хийх боломж бүхий нөөцтэй 5 оронтой цифрээр илэрхийлэгдсэн Монгол Улсын шуудангийн нэгдсэн код юм.
- 2.2. “Мэдээллийн сан”¹ гэж бүсчлэлийн код, түүнтэй хамт хэрэглэгдэх шуудангийн хаягийн бусад бичвэр, байршлын зураглалыг багтаасан өгөгдлүүдийг цаашид өргөтгөх боломжтойгоор үүсгэсэн баазыг хэлнэ.
- 2.3. “Хаягийн бүс”¹ гэж зорчих хэсэг буюу авто замаар тусгаарлагдсан үл хөдлөх объектод хамрагдах байгууллага, гэр болон орон сууцны нэг хороолол буюу түүнтэй ижил суурин хэсгийг ойлгоно.

Гурав. Бүсчлэлийн кодыг оноох, олгох

- 3.1. Хүн амын суурьшилтай холбогдон шинээр хаягийн бүс үүсэхэд Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) “Шуудангийн тухай хууль”-ийн 9.1.3 дахь заалтын дагуу зип кодыг онооно.
- 3.2. Хуулийн этгээд өөрийн хэрэглээнд зип код авах хүсэлтээ дор дурдсан материалыг бүрдүүлэн гаргасан тохиолдолд Зохицуулах хороо ажлын 14 хоногийн дотор тухайн хаягийн бүсийн кодын нөөцийг үндэслэн олгоно. Үүнд:
- Зип код олгохыг хүссэн албан бичиг;
 - Улсын бүртгэлийн гэрчилгээ болон иргэний үнэмлэхний баталгаажсан хуулбар;
 - Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар.

¹ Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 200 тоот тогтоолоор батлагдсан “Бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам”-д заасан нэр томъёо.

3.3. Зохицуулах хорооноос хүсэлт гаргасан хуулийн этгээдэд код олгосон тухай гэрчилгээ олгоно.

3.4. Хуулийн этгээдэд зип код олгохтой холбогдон гарах зардлыг санхүүжүүлэхэд зориулж Зохицуулах хорооны 2007 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлс тогтоох журам”-ын 3 дугаар зүйлд заасны дагуу төлбөрийг төлнө.

Дөрөв. Мэдээллийн санг бүрдүүлэх, түүнд өөрчлөлт оруулах

4.1 Зохицуулах хороо нь Нийслэлийн хот байгуулалт, төлөвлөлт болон хөдөө орон нутгийн төлөвлөлт хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хаягжуулалтын мэдээллийг үндэслэн жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр нэгтгэн мэдээллийн санг бүрдүүлнэ.

4.2 Зохицуулах хороо нь мэдээллийн санд жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр баяжилт хийнэ.

4.3 Зохицуулах хороо нь шуудангаар үйлчлүүлэгчийн хаягийн тухай мэдээллийг шуудангаар үйлчлэгчдээс хагас жил тутамд авч нэгтгэн мэдээллийн санд нэмэлт, өөрчлөлт оруулна.

4.4 Мэдээллийн санг шаардлагатай төрийн захиргаа, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад хэрэглүүлэх, лавлагаа олгох, нийтэд мэдээлэх ажлыг www.zipcode.mn сайт болон хэвлэмэл материалаар дамжуулан хүргэнэ.

Тав. Мэдээллийн санд тавигдах шаардлага

5.1. Мэдээллийн сангийн өгөгдөл дараахь бүтэцтэй байна.

- Хаягийн бүсийн нэр, зип код;
- Хаягийн бүсэд байрлах дүүрэг, гудамжны нэр;
- Хаягийн бүсэд байрлах албан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, барилга байгууламжийн дугаар.

5.2. Мэдээллийн сангаас хайлт хийхэд хялбар болгон өгөгдлүүдийг дор дурдсанаар төрөлжүүлнэ.

- Хаягийн бүсийн нэрээр буюу хот, гудамжны нэр, аймаг сум багийн нэрээр;
- Зип кодоор;
- Эрхэлдэг үйл ажиллагааны чиглэлээр, (тухайн хаягийн бүсэд байрлах төрийн захиргаа, аж ахуйн нэгж, албан байгууллагуудын).

5.3. Мэдээллийн сангийн зураглалд дараахь элементүүдийг харуулсан байна.

- Улаанбаатар хотод барилга байгууламж, гэр хороололын гудамж, зам талбайн байршил, хаягийн бүсийн хил, зип код;
- Хөдөө орон нутагт аймаг, сум, багийн байршил хаягийн бүсийн хил, зип код.

----- о О о -----